

УЛААНБААТАР ХОТЫН НУТАГ ДЭВСГЭРТ
ЕРДИЙН ХӨСГӨӨР АЯЛАХ, АЯЛУУЛАХ ЗӨВЛӨМЖ

1. Зөвлөмжийн зорилго

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Улаанбаатар хотын бүсэд ердийн хөсгийн аяллыг дэмжиж, гадаадын жуулчин, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, нүүдлийн соёл иргэншлийг өвлөх, түгээн дэлгэрүүлэх, энэ үйлчилгээг эрхлэх аж ахуйн нэгж, морь, тэмээн аяллын хөтөч, хөтөч-тайлбарлагч нарт зориулан энэхүү зөвлөмжийг боловсруулав.

2. Зөвлөмжийн нэр томъёо

Энэ зөвлөмжид хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

1. **“Ердийн хөсгийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж”** гэж өөрийн морь, тэмээ уналгаар морь, тэмээн аяллын хөтөч, хөтөч-тайлбарлагчтайгаар иргэн, жуулчдад ердийн хөсгийн цогц үйлчилгээг үзүүлж байгаа ашгийн төлөө аж ахуйн нэгжийг,
2. **“Хөтөч-тайлбарлагч”** гэж аялал жуулчлалын хөтөлбөрийн дагуу жуулчинд газарчлан, орчуулга, тайлбар хийх хувь хүнийг,
3. **“Морин болон тэмээн аяллын хөтөч”** гэж тухайн морь, тэмээг хөсгийн аялалд зориулан сургасан, ердийн хөсгийн аяллын бэлтгэлийг хангагч, газарлагч, дадлага, туршлагатай, хувь хүн, иргэнийг хэлнэ.

**3. Ердийн хөсгөөр аяллын үйлчилгээ эрхэлж буй
аж ахуйн нэгж, хөтөч нарт өгөх зөвлөмж**

1. Ердийн хөсгийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, морь, тэмээн аяллын хөтөч, хөтөч-тайлбарлагч нь / цаашид “үйлчилгээ үзүүлэгч” гэх / тэмээ, морины зан авирыг сайн мэддэг, мал аж ахуй эрхэлж байсан дадлага туршлагатай байна.
2. Аялалд зориулагдсан номхон, уналга, эдэлгээнд дадсан морь, тэмээг шаардлага хангахуйц эдлэл, хэрэгслийн хамт, аялагчдын тоог харгалзан бэлтгэнэ.
3. Ердийн хөсгийн үйлчилгээ үзүүлэгч нь дүүрэг, орон нутгийн мал, эмнэлгийн албанаас морь, тэмээний эрүүл байдлын шинжилгээний дүгнэлт авсан, урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан бичиг баримттай байна.
4. Аялалд хэрэглэж байгаа тэмээ, морины эзэн мөн болохыг тодорхойлсон хорооны засаг дарга, цагдаагийн тодорхойлолттой байх ба эсвэл тэмээ, адуугаа гэрээгээр унуулж, эдлүүлж байгаа тохиолдолд албан ёсны гэрээтэй байна.

5. Мөн тухайн дүүрэг, хорооны нутаг дэвсгэр, жуулчны бааз, байгалийн үзэсгэлэнт газарт иргэд, жуулчдад морь, тэмээгээр үйлчлэх зөвшөөрлийг байгаль хамгаалагч, аж ахуйн нэгж, газрын эзнээс авч, гэрээ байгуулсан байна.
6. Морь, тэмээн хөсгөөр аялуулахдаа аяллын маршруттай, аяллын үед байгаль, орчин, түүхэн дурсгалт газар, үндэсний соёл, зан заншлыг тайлбарлан таниулах хөтөлбөртэй байна.
7. Үйлчлүүлж буй иргэдийг уналга, хөсгөөс унах, осолдохоос сэрэмжилсэн бүхий л нөхцөлийг хангахаас гадна аюулгүй байдлын зөвлөмжийг сайтар өгч, аялах явцад анхаарал, сонор сэрэмж байнга тавьж ажиллана.
8. Морь, тэмээ, ердийн хөсөг нь унахад тохиромжтой биед эвтэй, үндэсний хэв загварыг хадгалсан, бүрэн бүтэн эмээл, хазаар, дөрөө, хөсөг тэрэг зэрэг эдлэл, тоноглолоор бүрэн хангагдсан байна.
9. Морь, тэмээн аяллын хөтөч, хөтөч-тайлбарлагч нар нь үндэсний өв соёлыг харуулсан дээл хувцас, эдлэлтэй, найрсаг дотно харьцаатай байна.
10. Ердийн хөсгийн үйлчилгээ эрхлэх чиглэлээр нэгдсэн зохион байгуулалтад орж, туршлагаа солилцож, хамтарсан сургалт дадлагад хамрагдсан байна.
11. Ердийн хөсгийн аялалд явах хүний тоо болон аяллын хугацаанд тохирсон хүнсний эрүүл ахуйн шаардлага хангасан хоол, хүнс, ундны ус бэлдэж нөөцлөн үйлчилгээ үзүүлнэ.
12. Аяллын үед шаардлагатай үед хэрэглэх сэлгээ морь, тэмээтэй, эдлэл, хэрэгслийн нөөцтэй байна.
13. Үйлчилгээний тогтсон үнэ тарифыг мөрдөнө. Тохиролцсон үйлчилгээний үнээс илүү төлбөр авахыг хориглоно.
14. Хэт ядарсан болон согтуурсан хэвийн бус хүнд үйлчлэхээс татгалзана.
15. Морь, тэмээн аялал эхлэхээс 30-аас доошгүй минутын өмнө унах морьдыг хөтөч-тайлбарлагч, морин хөтөч нар хамтран эмээллэж бэлэн болгох.
16. Морь, тэмээ унаж буй 5 жуулчин тутамд нэгээс цөөнгүй хөтөч ажиллуулах, морь, тэмээ унахад тохиромжтой гутал, хувцастай эсэхийг шалгаж, зөвлөнө.
17. Морь, тэмээн аяллын үед ахлах хөтөч аяллыг удирдан хөсгийн толгой хэсэгт явж, явган ба хөтөч-тайлбарлагч нар аяллын сүүл хэсэгт “цоожлон” явна.
18. Аяллын үед бүх хүмүүс хоорондоо 2-3 м-ийн зайтай цуваагаар явах ба хөтчийн заавраар хурдыг тохируулж; нэг өдөрт 45 км-ээс ихгүй замыг туулж, аяллын дундуур 2 цаг тутамд тэмээ, мориноос буулгаж амраах, биеийн чилээг гаргах зэргээр тав тухтай байдлыг хангана.
19. Аяллын хөтөч, хөтөч-тайлбарлагч нар нь морь, тэмээн аялал эхлэхээс хагас өдрийн хугацаагаар үйлчлүүлэгч нарт морь, тэмээний ааш араншин, хэрхэн харьцах, тоног хэрэгслийг хэрхэн хэрэглэх, мордох, жолоодох, буух талаар биечлэн үзүүлж, зөвлөгөө өгч, дадлага хийлгэнэ.
20. Аялагч морь, тэмээ унах үед хөтөч-тайлбарлагч, хөтөч нар эмээл, тохошны байрлал, оломны чанга, сул, эмээл, хазаар, бурантагны бүрэн бүтэн байдлыг хянаж, эмээл, тохош хөдөлсөн байвал даруй хэвийн байдалд оруулна.
21. Аяллын үеэр ямар нэг асуудал гарч шийдвэрлэх тохиолдолд аяллын группийн ахлагч, хөтөч-тайлбарлагч нар тэмдэглэл хөтөлсөн байна.
22. Аяллын явцад ямар нэг эрсдэл гарсан үед анхны тусламж үзүүлэх мэдлэг, дадлагатай байхаас гадна эмийн сан, боолт, чиг зэргийг бэлэн авч явна.

4. Морин аяллаар аялагчдад өгөх зөвлөмж.

Морин аялалд анхаарах нийтлэг зүйл:

1. Хөтчөөс морь хэрхэн жолоодох, залж чиглүүлэх, морь уналгааны эд хэрэглэлийг ашиглах талаар зөвлөгөө авна.
2. Тухайн морийг уналгаанд сургасан эсэхийг лавлаж, эхлээд морины хөтчөөр унаж үзүүлэхийг хүсэх хэрэгтэй.
3. Моринд мордохоос өмнө морины эдлэл хэрэглэл бүрэн, бүтэн байгаа эсэх болон танд тохирч байгааг сайтар шалгаарай. Хэрвээ эдлэл хэрэглэл нь ямар нэгэн эвдрэл гэмтэлтэй, өнгө үзэмж муутай байвал солиулж аваарай. Моринд мордох, буухдаа заавал морины хөтчийн тусламжийг авна.
4. Аялалд гарахаас өмнө эмээл нь танд тохирч байгаа эсэхийг шалгаарай. Хэтэрхий хатуу байвал зөөлөвч авах, эсвэл өөр эмээлээр солиулна.
5. Морин аяллын хөтчийн тайлбарыг сайн сонсож, шаардлагыг биелүүлэх хэрэгтэйг анхаарна.
6. Янз бүрийн огцом хөдөлгөөний улмаас сэдрэх өвчинтэй эсвэл хагалгаа хийлгэсэн бол морин аяллаас татгалзаарай.

Моринд мордохдоо анхаарах зүйл:

1. Мориндоо мордохын өмнө өөрийн унах гэж буй мориныхоо эд хэрэглэлийг сайн шалгах. Ногт, жолоо цулбуур, эмээлийн олом, жирмийг чангарсан, дөрөө холбоос байгаа эсэхийг шалгах, шалгуулах
2. Мориныхоо баруун гар талд нь буюу хойд хоёр хөлд нь ойрхон зогсож болохгүй, морийг илж таалж болохгүй.
3. Дөрөөний оосрыг уртасгаж богиносгож болдог учраас нэг удаа мориндоо мордож, дөрөөний оосрыг таарсан эсэхийг шалгаж өөртөө тохируулж унах.
4. Мориндоо мордохдоо жолоо цулбуураа зүүн гартаа эвхэж, богиновтор барьсан байх ба мориныхоо зүүн гар талаас нь зүүн хөлийг дөрөөнд мөчидхөн /мултрахааргүй/ хүч өгөн гишгэж мордоно.
5. Хөдлөхдөө жолоог бага зэрэг тавьж “Чүү” гэхэд морь урагш явна.
6. Жолоо цулбуураар морио хөтлөх болон унахдаа гараа ороож барих гогцоо гаргана. Гогцоог унжуулах, чирэх, морины цавьд нь хүрэхээр, хөлд нь орооцолдохоор авч явж болохгүй.
7. Морь унаж явах үедээ жолоогоо сул тавьж болохгүй.
8. Эмээл дээр мордсоны дараа та өөрийнхөө хөлийг дөрөөнд лав хийлгүйгээр гутлынхаа хоншоороор дөрөөг гишгэж суугаарай.
9. Хэрэв лав дөрөөлбөл та мориноос унах үед хөл чинь дөрөөнөөс мултрахгүй мориноос чирэгдэх аюултай.

Морь унаж явах үед анхаарах зүйл:

1. Жолоогоо сул тавилгүй морийг гуядах, ташуурдахад морь тонгорч булгих аюултай.
2. Хэрэв та нэг гараараа морио жолоодъё гэвэл жолоо барьсан гараа явах зүг рүүгээ лавхан залах хэрэгтэй.

3. Хэрэв морь таны хүссэнээр явахгүй бол хөлөөрөө дарвихгүйгээр цулбуураараа зөөлөн гуядаж үзээрэй.
4. Морь унаж байх үедээ огцом чангаар хашгирч болохгүй. Янз бүрийн дуу авианаас морь үргэж давхих аюултай.
5. Морь унаж явах үед өөр морьтонгууд хажуугаар хашгирч давхиж өнгөрөх үед мориныхоо жолоог татасхийн явна. Учир нь таны унаж яваа морь тэдний морийг дагаж давхиж болзошгүй.
6. Морьтой явж байх замд морь мал үргэх, машин тэрэг хажуугаар өнгөрөх үед та морио энэ зүйлд дасгах зорилгоор жолоогоо бага зэрэг татаж зөөлөн гүүглэн, / дуугарч / өгөх хэрэгтэй.
7. Гол, горхи гатлах үед морины хөтөч Мориндоо ус уулгаж байвал та өөрийнхөө морины жолоог суллаж морио ус уулгаж болно.
8. Таны унаж байгаа морь байн байн өвс идэх гээд байвал жолоогоо татасхийн явна уу.
9. Хэрэв та удаан явахыг хүсвэл жолоогоо татвал морины явдал удааширна.
10. Морины явдал танд хатуу санагдвал та биеийн жингийнхээ ихэнх хэсгийг хоёр хөлөндөө өгч дөрөөн дээрээ гишгэн өндийж явж үзээрэй.
11. Гол гатлах үед морин хөтчийн гаталсан замаар дагаж гараарай.
12. Олон морьд зэрэг унах, газрын уруу болон гэрийн зүг явахад морьд даган давхидаг тул жолоогоо бага зэрэг татаж явах нь зүйтэй.
13. Морь хурдлах үед та сандарснаас болж хашгирч орилж болохгүй. Тэгвэл морь улам хурдан давхих болно. Энэ үед морио зогсоох ямар нэг үг хэлсний хэрэггүй зөвхөн жолоогоо сайн татах ба зогсохгүй бол жолооныхоо баруун юм уу эсвэл зүүн тал руу нь алгуур татаж эргүүлэх хэрэгтэй. Ингэхдээ өөрөө татсан талынхаа эсрэг тал руу унахаас болгоомжлоорой.
14. Мориороо хурдан давхихыг хүсвэл газрын бартаа, гуу жалга огтоно зурамны нүх хад чулуу байгаа эсэхийг сайтар ажиглаж харах хэрэгтэй.
15. Давхиж байх явцдаа морь нүхэнд бүдрэх тохиолдол их байдаг тул эмээлийн бүүрэгнээс нэг гараараа барьж, хоёр хөлөөрөө морио сайн хавчиж явах ёстой.
16. Морь унаж явах үед болон зогсох үед мориноосоо буулгүй хувцсаа тайлах буюу өмсөх, зураг авах, тамхи татах, юм уух, үүргэвч цүнхээ авах, уудлах, хөлөө хэт дээр өргөх, хамаагүй дайжин хөдөлгөх, орилж хашгирах зэрэг үйлдэл хийхгүй байх.
17. Хоорондоо уралдахыг хориглоно.
18. Морь унаж байгаа хүмүүс хоорондоо 2-3 м зайтай цуваагаар явна.
19. Морин аяллын үеэр нэг өдөрт 45 км-ээс ихгүй замыг туулах.
20. Эгц өөд буюу хад асгатай, морь явахад бэрхшээлтэй газарт мориноосоо бууж морио хөтөлж яваарай.

Мориноос буух үедээ анхаарах зүйл:

1. Анх морь унаж байгаа бол буухдаа заавал хөтчийн тусламжтайгаар бууна. Хэрвээ өөрөө буухыг хүсвэл бусад мориноос нэлээн зайдуу газар очиж буувал танд аюулгүй байх болно.
2. Мориноос буухдаа мориныхоо зүүн тал руу бууна. Гартаа цулбуур, жолоогоо ороолгүйгээр эвхэж богиновтор атган, зүүн хөлөө дөрөөнөөсөө мултлахад

хялбар болгон буух ёстой. Учир нь таныг бууж амжаагүй байхад морь хөдөлвөл та хөлөө дөрөөнөөс салгаж авч чадаагүйгээс болоод моринд чирэгдэх аюултай.

3. Арзгар ултай, өндөр өсгийтэй гутал өмсөж болохгүй. Мориноос бууж амрах үедээ морио сул тавьж болохгүй. Морины хөтчид заавл өгөх ёстой.
4. Та мориноос бууж амрах бүрдээ хөл, нуруу гарын дасгал бага зэрэг хийж явбал таны бие маргааш нь булгарч өвдөхгүй.
5. Та орой унтаж амрахын өмнө бүжиглэх юм уу багахан хугацаагаар гүйх буюу биеийн тамирын дасгал хийгээрэй.

5. Тэмээгээр аялах аялагчдад өгөх зөвлөмж

Тэмээн аялалд анхаарах нийтлэг зүйл:

1. Хөтчөөс тэмээг хэрхэн жолоодох, залж чиглүүлэх, эд хэрэглэлийг ашиглах талаар зөвлөмж авна.
2. Тухайн тэмээг уналгад сургасан эсэхийг лавлаж, эхлээд хөтчид унуулан өөрөө ажиглана.
3. Тэмээнд мордохоос өмнө эдлэл хэрэглэл бүрэн, бүтэн байгаа эсэх болон танд тохирч байгаа эсэхийг сайтар шалгаарай. Хэрвээ эдлэл хэрэглэл нь ямар нэгэн эвдрэл гэмтэлтэй, өнгө үзэмж муутай байвал солиулж аваарай.
4. Аялалд гарахаас өмнө өөрөө тэмээг хэвтүүлэх, босгох дасгал хийгээрэй.
5. Тэмээнд мордох, буухдаа заавал хөтчийн тусламж авна.
6. Аялалд гарахаас өмнө эмээлтэй аялах уу, эсвэл энгийн зөөлөвчтэй аялах уу гэдгээ хөтөчтэй зөвлөлдөх хэрэгтэй.
7. Хөтчийн тайлбарыг сайн сонсож, зөвлөмжийг биелүүлнэ.
8. Тэмээний явдал морины явдлыг бодвол эв муутай байдаг.
9. Тэмээний буйлаар хамаагүй оролдох эсвэл өмнө нь зогсвол ааш зан гаргадаг.

Тэмээнд мордохдоо анхаарах зүйл:

1. Тэмээнд мордохын өмнө бурантаг, буйл, эдлэл, хэрэглэлийг сайн шалгах.
2. Хэрвээ эмээлтэй бол олом жирэм нь чанга, сул эсэх, дөрөө холбоос байгаа эсэхийг шалгаарай.
3. Мордохдоо хөтчийн тусламж авахыг зөвлөж байна.
4. Хэрвээ эмээлтэй тэмээнд мордох гэж байгаа бол зүүн хөлийг дөрөөнд мөчидхөн /мултрахааргүй/ хүч өгөн гишгэж мордоно.
5. Эмээлтэй тэмээ унаж байгаа бол дөрөөний оосрыг таарсан эсэхийг шалгаж өөртөө тааруулж аваарай.
6. Тэмээнд мордохдоо буйлыг зүүн гартаа эвхэж богиновтор барьсан байвал тохиромжтой .

Тэмээ унаж явах үедээ анхаарах зүйл:

1. Буйл нь нэг талдаа байдаг болохоор жолоодоход жаахан төвөгтэй байдаг.

- Сайн сургасан тэмээг биеэрээ болон гараараа чиглүүлэхэд өөрөө чигээ олдог.
2. Тэмээг ташуурдах нь тийм ч оновчтой арга биш. Хурдан явахыг хүсвэл хөлөөрөө дарвиж өгөх хэрэгтэй.
 3. Тэмээ унаж байх үедээ огцом чангаар хашхирах хэрэггүй. Янз бүрийн дуу авианаас тэмээ үргэж давхих аюултай.
 4. Өргөн тавхайтай учраас шавар шавхайтай, намгархаг газраар явахад халтирах аюултай.
 5. Тэмээгээр явж байх замд тэмээ мал үргэх, машин тэрэг хажуугаар өнгөрөх үед тэмээгээ энэ зүйлд дасгах зорилгоор жолоогоо бага зэрэг татаж удаан явах хэрэгтэй.
 6. Гол болон горхи гатлахдаа анхааралтай байгаарай. Ус цацаж таны хувцсыг норгож магадгүй. Хөтчийн араас гол горхи гатлах нь хамгийн аюулгүй арга болно.
 7. Таны унаж байгаа тэмээ байн байн өвс идээд байвал жолоогоо татасхийн явна уу.
 8. Газрын уруу явахад жолоогоо бага хэмжээгээр татаж яваарай. Аль болох тэгшхэн газрыг сонгож яваарай. Тэмээ хурдлах үед та сандарснаас болж хашгирч, орилж болохгүй, бурантгийг татаж зогсоогоорой. Хэрэв хашгирвал тэмээ улам хурдан давхих болно.
 9. Тэмээгээр хурдан давхихыг хүсвэл газрын бартаа гуу, жалга, оготно, зурамны нүх, хад чулуу байгаа эсэхийг сайтар ажиглаж харах хэрэгтэй.
 10. Давхиж байх үедээ тэмээ нь амьтны нүхэнд бүдрэх тохиолдол их байдаг тул эмээлийн бүүрэгнээс эсвэл бөхнөөс сайн барьж, хоёр хөлөөрөө тэмээг сайн хавчиж явна.
 11. 2-3 цаг тутам тэмээнээс бууж биеийн чилээгээ гаргаж, амарч байгаарай.
 12. Та тэмээгээр өдөрт дээд тал нь 35 км зам туулах боломжтой.
 13. Нартай өдрүүдэд тэмээ унахад нойр хүрдэг. Хэрвээ таны нойр хүрээд байвал хажууд дахь хүнтэйгээ юм ярих зэргээр нойроо сэргээж болно.
 14. Тэмээн дээр унтаж, нойрмоглож болохгүй.

Тэмээнээс буух үедээ анхаарах зүйл:

1. Тэмээнээс буухдаа заавал хөтчийн тусламжийг авна.
2. Тэмээ хэвтэхэд эвгүй байдаг учраас бөхөөс нь сайн тэвэрч барих хэрэгтэй. Тэмээ эхлээд урьд хоёр хөлөөрөө өвдөглөж, дараа нь арын хоёр хөлөө нугална. 4 хөлөө нугалсны дараа ажмаар хэвтэх бөгөөд бүрэн хэвтсэний дараа хөлөө өөртөө тохиромжтой болгон хөдөлгөдөг. Тийм учраас тэмээ хэвтсэний дараа 10 секунд орчим хүлээж байж бууна.
3. Хэрвээ та өөрөө буухыг хүсвэл бусад тэмээнээс нэлээн зайдуу газар очиж буувал танд аюулгүй байх болно.
4. Тэмээнээс буухдаа тэмээний зүүн тал руу бууна.
5. Хэрвээ эмээлтэй тэмээнээс буух гэж байгаа бол хоёр хөлөө дөрөөнөөс сугалахад хялбар болгон буух ёстой. Учир нь таныг бууж байхад тэмээ хөдлөх, гэнэт босох хөдөлгөөн хийвэл та хөлөө дөрөөнөөс салгаж авч чадаагүйгээс болоод тэмээнд чирэгдэх аюултай. Тиймээс арзгар ултай, өндөр өсгийтэй гутал

өмсөж болохгүй.

6. Буйлыг өөрийн хөл, гараас уяж болохгүй тэмээ гэнэт үргэвэл та өөрөө чирэгдэх аюултай.
7. Тэмээнээс буусны дараа тэмээгээ сул тавьж болохгүй. Хөтчид заавал өгөх ёстой.

Жич тайлбар:

1. Энэхүү зөвлөмж нь ердийн хөсгөөр аяллын үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, хөтөч нарт зориулагдсан бөгөөд орон нутгийн онцлог, ахуй нөхцөл, цаг агаарын байдал, морь, тэмээний зан авир, хөсөг уналгыг харгалзан баяжуулж ашиглах нь зүйтэй.
2. Ердийн хөсгийн аяллыг эрхлэгч нь иргэд, жуулчдын аюулгүй байдлыг онцлон анхаарч, соёлтой боловсон үйлчилгээг эрхэмлэж, үндэсний зан заншлыг дээдлэн түгээн дэлгэрүүлэхэд ажил, үйлсээ зориулахыг хүсье.

